

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хэрэгжилт

Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу / Дорноговь аймгийн Засаг дарга/-тай Төсвийн шууд захирагч /Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга/ нь 2024 онд нийт 28 бүтээгдэхүүн -Үүнээс "ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ"-ийн хүрээнд 3 бүтээгдэхүүн сонгон гүйцэтгэн нийлүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан ажилласан. -Цаг уур, орчны технологийн хэлтсийн 48, Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн 9, Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн 6, гэрээт 3 ажилтан нийт 66 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын 9-р хавсралтын дагуу I, II, III улирлаар үнэлж дүгнэсэн.

Мөрдөж буй хууль, дүрэм журам, актын хэрэгжилт: Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны А/83 дугаар тушаал, Төвийн даргын 2024 оны А/01 тоот тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу Цаг уур, орчны технологийн хэлтэс, Мэдээлэл үйлчилгээний хэлтэс, Захиргаа санхүү, аж ахуйн хэлтэс гэсэн 3 хэлтэс, гэрээт албан хаагчтай шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын тасралтгүй хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Оны эхэнд төсвийн ерөнхийлөн захирагч болох ЦУОШГ-ын дарга, Аймгийн засаг дарга нартай “Үр дүнгийн гэрээ” байгуулан ажилласан. 2024 онд Цаг уур орчны шинжилгээний газрын даргын тушаал 6, Засгийн газрын тогтоол 2, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал 1, Аймгийн засаг даргын захирамж, албан даалгавар 4 гарсаныг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын даргын тушаал нийт 73 гарсанаас “Боловсон хүчин”-тэй холбоотой тушаал 44, үүнээс ажилд авах тухай 20, ажлаас чөлөөлсөн 12, сануулах шийтгэл оногдуулах тухай 1, ажил хавсран гүйцэтгэх тухай 6, сэлгэн ажиллуулах тухай 4 тус тус гарсан байна. “Албан ажлын” холбогдолтой 29 тушаал гарсан. Шинээр ажилд орсон ажилтны хувийн хэргийн материалыг бүрдүүлж, ажлын байрны тодорхойлолтыг гаргаж, танилцуулан баталгаажуулсан. Байгууллагын нийт ажилтан албан хаагчдын 2024 оны шинэчилсэн судалгааг гаргасан. Дэлхийн цаг уурын баярын өдрийг тохиолдуулан ЦУОШГазрын “Хүндэт Жуух” бичгээр 4 хүнийг салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа хөдөлмөрийг нь үнэлж, шагнаж урамшуулсан байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт: Тус байгууллагад 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдах байгууллагаас болон бусад байгууллагаас: • Даргын тушаал 73, • Өргөдөл гомдол 12-ыг хүлээн авч бүртгэлд хөтлөн даргад танилцуулж, 12-н өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлүүлсэн. Хугацаанд шийдвэрдлэгдээгүй хүлээдэж буй өргөдөл гомдол байхгүй. • Дээд байгууллага болон харъяа удирдах албан тушаалтны шийдвэр зэрэг ирсэн бичиг 126-ийг хүлээн авч, цохолт хийлгэн үүнээс 45 хариутай бичиг байснаас цаг хугацаанд хариуг шийдвэрлэж бүртгэл хяналтын карт хөтөлсөн. • 175 албан тоот, бичгүүдийг төлөвлөн гаргаж холбогдох газруудад хүргэсэн. Ажилчдын ээлжийн амралтын хуудсыг цагийн график болон ээлжийн амралтын хуваарийн дагуу амралтын хуудсыг гаргаж батлуулан ЗСААХэлтсийн дарга бөгөөд нягтлан бодогчид хүлээлгэн өгч ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар 59 албан хаагч ээлжийн амралтыг эдэлсэн байна. Орон нутгийн салбар 5 станц, 8 харуулаас болон дээд газраас шуудангаар 213 баримт бичиг, тайлан материал ирснийг хүлээн авч тухай бүрт нь дарга, инженер, техникч нарт хүлээлгэн өгсөн ба сар бүрийн хариу зааварчилгаа, сарын мэдээ, бусад зөвлөмж зааврууд зэрэг 25 баримт бичгийг сумд, салбаруудад шуудангаар явуулж бүртгэл хөтөлсөн. Шинээр ажилд орсон 4-н ажилтны хувийн хэргийн материалыг бүрдүүлж, Хөдөлмөрийн гэрээг гаргаж танилцуулан баталгаажуулсан.

Төсөв санхүү: Байгууллагын батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж буй нийт албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем, хүний нөөцийн программд, мөн ирсэн,

явуулсан бичгийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр илгээсэн., байгууллагын А, Б тушаал шийдвэрийг тушаал шийдвэр программд тус тус шивж оруулах ажлыг дуусгасан. Төрийн албаны хүний нөөцийн судалгаа, ХАСХОМ гаргах албан тушаалтны судалгаа, Ажилчдын боловсролын талаарх судалгаа, Мэргэшлийн зэргийн шалгалтанд орох инженер, техникч нарын судалгаа, 40-өөс дээш насны ажилчдын судалгаа, 2024 онд тэтгэвэрт гарах ажилчдын судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын судалгаа, ажилчдын 0-18 насны хүүхдийн судалгаа, шагналын судалгаа, ажилд орсон иргэдийн судалгаа, нийт албан хаагчдын судалгаа, ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг тус тус цаг тухайд гаргаж ажилласан. -Нийт 66 үндсэн ажилчин албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна. Үндсэн ажилчдаас магистр 2, бакалавр зэрэгтэй 30, дипломын дээд 4, тусгай дунд боловсролтой 5, бүрэн дунд боловсролтой 22, бүрэн бус дунд 2 боловсролтой ажилчидтай байна. Нийт ажилчдыг ажилласан жилээр нь авч үзвэл 1-5 жил ажилласан албан хаагч 21, 6-10 жил ажилласан 11, 11-15 жил ажилласан 10, 16-20 жил ажилласан 7, 21-ээс дээш жил ажилласан 16 албан хаагчтай ажиллаж байна. Тус төвд 18-35 насны 23 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 34.8%, 36-41 насны 21 хүн буюу нийт албан хаагчдын 31.8%, 42-с дээш насны 21 хүн буюу нийт албан хаагчдын 31.8% хувийг эзэлж байгаа нь залуу боловсон хүчнээр хангагдсан байгааг харуулж байна. Төсөв; 2024 онд 2,793,236.5 сая төгрөгийн төсөв батлагдаж эхний 11-р сарын байдлаар 2,295,575.4 сая төг-ийн гүйцэтгэлтэй, батлагдсан 66 орон тоотой үүнээс цалингийн санд 2,226,419.1 нийгмийн даатгалын сан 278,302.6 төгрөг батлагдаж, одоогоор цалин-1,889,444.6төг, НДШ- 207,488.5 төг-ийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын санал дүгнэлт: Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, төсөвт хөрөнгийн зарцуулалт, түүний үр дүн, тайлан тэнцлийн гаргалт, байгууллагын хоорондын тооцоо, өр авлага тэнцэл, эд хөрөнгийн тооллого хийсэн материал болон бусад санхүү, удирдлагын бичиг баримтыг хамт аймгийн Аудитын газарт хүргүүлэн хяналт шалгалт хийлгэсэн. Уг шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн.

Төсвийн хэмнэлт, хэтрэлт тайлбар шалтгаан: Монгол улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг бодит тоо баримтыг үндэслэн эрсдэлийг тооцож ЦУОШГазрын санхүү аж ахуйн хэлтсийн төсвийн мэргэжилтэнд хүргүүлсэн. 2024 оны төсвийн төсөлд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай зардлууд болох бичиг хэрэг, тээвэр шатахуун, хог хаягдлын хураамжийн төлбөр, хөдөлмөр хамгаалал зэргийг бодит байдалд ирсэн нэхэмжлэх баримтуудад үндэслэн бодитоор нэмж тусгасан. Төсвийн тодотголын саналаа 11 сарын байдлаар Тээвэр шатахуун, Бага үнэтэй түргэн элэгдэх, түлш халаалт, урсгал засвар, тээврийн хэрэгсэлийн оношилгоо, тээврийн хэрэгсэлийн татвар гэх мэт зардалууд хүрэлцэхгүй өр үүссэн тул ЦУОШГазарт зардал хооронд шилжүүлэх хүсэлт явуулан ажиллаж байна.

2024 онд БОАЖЯ болон ЦУОШГ-аас нийт ажилтнуудын ажиллах орчин, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх зорилгоор тодорхой төсвийн зардлыг шийдвэрлэж өгсөн. Үүнээс: Ай ти зон ХХК-45,220,000төгрөг Саммит ХХК-49,399,000 Технозон ХХК-12,850,000 төгрөгийн компьютер болон принтерийн худалдан авалт хийсэн.

Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг эхний хагас жилээр болон гуравдугаар улирлаар гарган УЦУОШГазрын санхүүгийн хэлтэсд хүргүүлэн нэгтгүүлж И-Балансанд

шивж илгээсэн. Нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 05-ны дотор цахимаар болон цаасаар, татварын тайланг улирал бүр цахимаар үнэн зөв гаргаж ХХАОТ ,НДШ-ийн байцаагчаар баталгаажуулдаг. Төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт батлгааг Санхүү төрийн сангийн хэлтэсийн даргаар батлуулж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 01-ны дотор УЦУОШГазрын төсөв хариуцсан мэргэжилтэн аймгийн төрийн сангаар баталгаажуулан хүргүүлэв. Байгууллагын шилэн дансны мэдээллийг системд тухай бүрт оруулах мэдээлэл-171 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээллийг бүрэн оруулж, гүйцэтгэлийг 100 хувьтай хэрэгжүүлж ажилласан.

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;

Байгууллагын батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж буй нийт албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем, хүний нөөцийн программд, мөн ирсэн, явуулсан бичгийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр илгээсэн., байгууллагын А, Б тушаал шийдвэрийг тушаал шийдвэр программд тус тус шивж оруулах ажлыг дуусгасан. Төрийн албаны хүний нөөцийн судалгаа, ХАХХОМ гаргах албан тушаалтны судалгаа, Ажилчдын боловсролын талаарх судалгаа, Мэргэшлийн зэргийн шалгалтанд орох инженер, техникч нарын судалгаа, 40-өөс дээш насны ажилчдын судалгаа, 2024 онд тэтгэвэрт гарах ажилчдын судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын судалгаа, ажилчдын 0-18 насны хүүхдийн судалгаа, шагналын судалгаа, ажилд орсон иргэдийн судалгаа, нийт албан хаагчдын судалгаа, ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг тус тус цаг тухайд гаргаж ажилласан. -Нийт 66 үндсэн ажилчин албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна. Үндсэн ажилчдаас магистр 2, бакалавр зэрэгтэй 30, дипломын дээд 4, тусгай дунд боловсролтой 5, бүрэн дунд боловсролтой 22, бүрэн бус дунд 2 боловсролтой ажилчидтай байна. Нийт ажилчдыг ажилласан жилээр нь авч үзвэл 1-5 жил ажилласан албан хаагч 21, 6-10 жил ажилласан 11, 11-15 жил ажилласан 10, 16-20 жил ажилласан 7, 21-ээс дээш жил ажилласан 16 албан хаагчтай ажиллаж байна. Тус төвд 18-35 насны 23 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 34.8%, 36-41 насны 21 хүн буюу нийт албан хаагчдын 31.8%, 42-с дээш насны 21 хүн буюу нийт албан хаагчдын 31.8% хувийг эзэлж байгаа нь залуу боловсон хүчнээр хангагдсан байгааг харуулж байна.

Төрийн үйлчилгээ, цаг агаарын мэдээ мэдээллээр үйлчлэх төлбөр хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;

1. Байгаль, цаг агаарын тусгай хэрэгцээний мэдээний үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх хүрээнд орон нутгийн төрийн байгууллага болон төрийн өмчит, хувийн хэвшлийн байгууллагууд, уул уурхайн компаниудад БОС-н 2020 оны 4-р сарын 24-ний өдрийн А/298 тоот тушаал, архивын ерөнхий газрын даргын 2023 оны А/24 тоот тушаалын дагуу цаг уурын байгууллагаас үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт, үнэ тарифийн талаар мэдээлэл хүргүүлж, хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн. Өмнөх онуудад УБТЗ-ын харьяа Төмөр замын Замын 4-р анги, Сайншанд татах хэсэг, “Чандмань Илч” ОНӨХХКомпанитай гэрээ байгуулан тусгай хэрэгцээний цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилдэг байсан бол 2024 онд шинээр УБТЗ-н харьяа Дохиолол холбооны 3-р анги, Дорноговь АЗЗА ТӨХК, Норинко интернейшнл кооперэйшн лтд, пайплайн төлөөний газартай гэрээ байгуулан ажиллаж байна. Байгууллага болон ард иргэдийн хүсэлтийн дагуу цаг агаарын лавлагаа, тодорхойлолт мэдээгээр үйлчилж, 16.282.100.0 төгрөгний орлого төвлөрүүлсэн. 2. БОШЛ-ийн нэмэлт хяналт шинжилгээгээр: 2024 онд давхардсан тоогоор 41 аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтийн дагуу агаар болон хөрс, усны шинжилгээний дээжийг технологийн дагуу авч

шинжлэн шинжилгээний үр дүнг холбогдох газруудад хүргүүлсэн. Тус шинжилгээгээр агаарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжээг 123 дээжинд, тоосонцорын хэмжээг 123 дээжинд, хөрсний 110 дээжинд агрохимийн 6 үзүүлэлт, хаягдал усны нийт 49 дээжинд 8 үзүүлэлт, ундны усны 44 дээжинд 19 үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийгдэж нийт 18.000.000 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. 3. Архивын баримт, мэдээлийн сангийн мэдээллээр: Архивын баримт, мэдээгээр байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн 15 хүсэлт хүлээн авч цаг уурын элементүүдэд түүвэр хийн холбогдох мэдээгээр үйлчлэв. Үйлчилгээний хөлс 1.522.500 төгрөгний орлого төвлөрүүлжээ.

-Байгууллагын хэмжээнд Төрийн байгууллагын цахим шууданг info@dornogovi.namem.gov.mn хаяг үүсгэсэн, www.e-mongolia.mn веб портал болон “E-Mongolia” гар утасны аппликейшн ашиглаж мэдээ мэдээлийг солилцож байна. -Дээд байгууллагатайгаа цаг уурын бүх төрлийн мэдээ, мэдээллийг дотоод сүлжээний 192.168.100.13 тоон хаягаар шуурхай дамжуулж байна. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж, иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр Аймгийн УЦУОШТөвийн албан ёсны веб хаяг болох <http://dornogovi.tsag-agaar.gov.mn/>, DSB, DTV телевиз, 70522511, 99294845 дугаар, “Дорноговь цаг агаар, орчны мэдээ мэдээлэл”, <https://www.facebook.com/dornogovimet> facebook хуудсаар дамжуулж хэрэглэгчдэд цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээгээр үйлчилдэг. Мөн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын “Масс мессеж” үйлчилгээгээр дамжуулан аймгийн онцгой комиссын гишүүд, малчид ард иргэдийн гар утсанд мессеж хэлбэрээр 1 удаагийн мессежийг Skytel-н дугаартай 1285 хэрэглэгч, Unitel-н дугаартай 2258 хэрэглэгч, Mobicom-н дугаартай 1302 хэрэглэгч, G-Mobile-н дугаартай 688 хэрэглэгч нийт 5533 иргэдэд дамжуулан ажиллаж байна. Alarm.tsag-agaar.gov.mn сайтанд анхааруулах мэдээг 535 удаа, сэрэмжлүүлэх мэдээг 274 удаа, урьдчилан сэргийлэх мэдээг 51 удаа нийт 860 мэдээ байршуулж, хэрэглэгчдэд хүргэсэн.

Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай:

- Байгууллагад хөтлөгдвөл зохих хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар албан бичиг хэргийг баримт бичгийн эмхтгэл MNS 5140-1:2021, 5140-2:2021, 5140-3:2021 “Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын дагуу албан дээр хөтлөгдөж буй 15 төрлийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг стандартын дагуу хөтөлж байна. Байгууллагын батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж буй нийт албан хаагчдын дэлгэрэнгүй мэдээллийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем, хүний нөөцийн программд, мөн ирсэн, явуулсан бичгийг ERP-e-mongolia төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр илгээсэн., байгууллагын А, Б тушаал шийдвэрийг тушаал шийдвэр программд тус тус шивж оруулсан. Орон нутгийн салбар 5 станц, 8 харуулаас болон дээд газраас шуудангаар 213 баримт бичиг, тайлан материал ирснийг хүлээн авч тухай бүрт нь дарга, инженер, техникч нарт хүлээлгэн өгсөн ба сар бүрийн хариу зааварчилгаа, сарын мэдээ, бусад зөвлөмж зааврууд зэрэг 25 баримт бичгийг сумд, салбаруудад шуудангаар явуулж бүртгэл хөтөлсөн.